Тэртээ 1886 оны энэ одор Чикаго хотод “Ажлын 8 цаг”-ийн горимд шилжих шаардлага тавьж зохион байгуулагдсан жагсаал цуглаанаас vvдэн 5 дугаар сарын 1-ийг “Олон улсын эв санааны нэгдлийн одор” болгон тэмдэглэж ирсэн тvvхтэй.

Энэ одрийг тохиолдуулан Монголын vйлдвэрчний эвлэлvvдийн холбоо ХБНГУ-ын Фридрих Эбертийн Сантай хамтран иргэд, ходолморчдийн дуу хоолойг бvх тvвшинд сонсож, бодит ажил болгох зорилгоор “Ходолморлох эрх” нээлттэй одорлогийг оноодор Сvхбаатарын талбайд зохион байгууллаа.Одорлогт МҮЭ-ийн салбар холбоод болон албан хаагчид оролцон хамтдаа дуу хоолойгоо нэгтгэн тайван жагсаал хийлээ.